



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/138

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.1, 3.6.3 дахь заалт, “2024 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 17 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Бат-Өлзий сумын төвийн шинэ суурьшлын бүсэд шинээр байгуулагдах цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих, нийтийн эзэмшлийн талбайн хашааг засварлах ажлыг “Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Зардалд шаардагдах 69,951,300 (жаран есөн сая есөн зуун тавин нэгэн мянга гурван зуу) төгрөгийг гэрээний дагуу, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч баримтжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

022301193